



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 29 (166)

## Монгол Улсын Хууль:

- *Нэтэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай*
- *Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай*

## Монгол Улсын Их Хурлын тогтоол:

- *Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай*

## Монгол Улсын Засгийн газрын тогтоол:

- *Өрхийн ажиргааны чадавхийг дэтжих Үндэсний хөтөлбөр батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2000 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2000 оны наймдугаар сарын 3 № 29 (166)

### Гарчиг

#### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

298. Хэлэлцээр хүлээн зөвшөөрч, түүнд нэгдэн орсныг  
соёрхон батлах тухай (2000-7-26-ны хууль) 518
299. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай  
(2000-7-26-ны хууль) 518
300. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай  
(2000-7-26-ны хууль) 518

#### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

301. Монгол Улсын Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн  
4 дэх хэсгийн заалтыг тайлбарлах тухай Дугаар 10 519
302. Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай Дугаар 11 519
303. Р.Амаржаргалыг Ерөнхий сайдын үүрэгт ажлаас  
чөлөөлөх тухай Дугаар 12 519

#### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

304. Сэнгэ-Очирын Лоосовт Монгол Улсын гавьяат тээвэрчин  
цол хүртээх тухай Дугаар 109 520
305. Баттөмөрийн Жамсранд Монгол Улсын ойн гавьяат  
ажилтан цол хүртээх тухай Дугаар 110 520
306. Цэвээний Өлзийхутагт Монгол Улсын гавьяат багш цол  
хүртээх тухай Дугаар 111 520
307. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 112 520
308. "Цэргийн цол олгох журам"-ын заалтад өөрчлөлт,  
нэмэлт оруулах тухай Дугаар 114 524

#### Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

309. Зарим орон сууц хувьчлах тухай Дугаар 89 524
310. Гэгээрлийн салбарын зарим байгууллагын  
менежментийг гэрээгээр гүйцэтгүүлэх тухай Дугаар 90 527
311. Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих Үндэсний  
хөтөлбөр батлах тухай Дугаар 93 528
312. Цагдаагийн байгууллагын талаар авах зарим  
арга хэмжээний тухай Дугаар 94 539
313. Хөтөлийн цемент, шохойн үйлдвэрийн талаар  
авах зарим арга хэмжээний тухай Дугаар 95 540



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 7 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

### ХЭЛЭЛЦЭЭР ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ, ТҮҮНД НЭГДЭН ОРСНЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Европын сэргээн босголт, дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрийг хүлээн зөвшөөрч, түүнд нэгдэн орсныг соёрхон баталсугай. **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА**

Л.ЭНЭБИШ

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2000 оны 7

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 7 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

### НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа "Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйг сайжруулах", Германы сэргээн босголтын зээлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа "Харилцаа холбоо 2 ба 3" төслүүдийн хүрээнд орон нутгийн нийтийн аж ахуй, харилцаа холбооны салбарын өргөтгөл, шинэтгэлд зориулан импортоор нийлүүлэгдсэн болон нийлүүлэгдэх тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, материалыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА**

Л.ЭНЭБИШ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 7 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

### ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа "Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйг сайжруулах", Германы сэргээн босголтын зээлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа "Харилцаа холбоо 2 ба 3" төслүүдийн хүрээнд орон нутгийн нийтийн аж ахуй, харилцаа холбооны салбарын өргөтгөл, шинэтгэлд зориулан импортоор нийлүүлэгдсэн болон нийлүүлэгдэх тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, материалыг гаалийн албан татвараас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА**

Л.ЭНЭБИШ



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 7 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

### Монгол Улсын Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалтыг тайлбарлах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

тогтоол гаргамагц зохих хууль, зарлиг, батламж, шийдвэр хүчингүй болно гэж ойлгоно;

1. Монгол Улсын Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 4 дэх хэсгийг дор дурдсанаар тайлбарласугай:

2/Үндсэн хууль зөрчсөн тухай

1/Монгол Улсын Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ нь Үндсэн хуульд нийцээгүй гэж Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргавал зохих хууль, зарлиг, батламж, шийдвэр хүчингүй болно." гэж заасныг Үндсэн хуулийн цэц эдгээр асуудлаар маргааныг эцэслэн хянан шийдвэрлэж

маргаантай холбогдох хууль, зарлиг, Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ нь Үндсэн хуулийн цэцийн тогтоол гартал хүчин төгөлдөр үйлчилнэ гэж ойлгоно.

2. Энэ тогтоолыг 2000 оны 7 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ДАРГА**

**Л.ЭНЭБИШ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 7 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

### Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6, Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 15 дугаар зүйл, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Энхбаярыг томилсугай.

2. Энэ тогтоолыг 2000 оны 7 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

1. Монгол Улсын Ерөнхий сайдаар Намбарын

**ДАРГА**

**Л.ЭНЭБИШ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 7 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

### Р.Амаржаргалыг Ерөнхий сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын шинэ Ерөнхий сайдыг томилсонтой холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг, дөчдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Ерөнхий сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Шинээр Засгийн газрын гишүүн-сайд нарыг томилогдтол үүрэгт ажлаа гүйцэтгэж байхыг Засгийн газрын гишүүдэд даалгасугай.

3. Энэ тогтоолыг 2000 оны 7 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

1. Ринчиннямын Амаржаргалыг Монгол

**ДАРГА**

**Л.ЭНЭБИШ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 7 дугаар сарын 07-ны өдөр

Дугаар 109

Улаанбаатар хот

Сэнгэ-Очирын Лоосовт Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээх тухай

Авто тээврийн салбарт үр бүтээлтэй ажиллаж нисэх онгоцны түлшийг хөдөө орон нутагт олон жил сааталгүй тээвэрлэн, нислэгийн найдвартай үйлчилгээг хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монголын иргэний агаарын тээврийн "МИАТ" компанийн шатахуун, тусгай үйлчилгээний

автобаазын жолооч Сэнгэ-Очирын Лоосовт Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 7 дугаар сарын 07-ны өдөр

Дугаар 110

Улаанбаатар хот

Баттөмөрийн Жамсранд Монгол Улсын ойн гавьяат ажилтан цол хүртээх тухай

Ой, ангийн аж ахуйн байгууллагыг олон жил үр бүтээлтэй удирдаж, мод үржүүлгийн ажлыг технологийн дагуу хийж ойг нөхөн сэргээх, хамгаалан арвижуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Сэлэнгэ аймгийн Ой, ан төвийн

дарга Баттөмөрийн Жамсранд Монгол Улсын ойн гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 7 дугаар сарын 07-ны өдөр

Дугаар 111

Улаанбаатар хот

Цэвээний Өлзийхутагт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Боловсрол, шинжлэх ухааны байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж монгол хэл судлал, заах ардын шинжлэх ухааныг хөгжүүлэх, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, өсвөр үеийг сурган хүмүүжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Боловсролын хүрээлэнгийн зөвлөх Цэвээний

Өлзийхутагт Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 7 дугаар сарын 07-ны өдөр

Дугаар 112

Улаанбаатар хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэр, үйлчилгээ, эрүүл мэнд, боловсрол, соёл урлаг, хөдөө аж ахуй, төр захиргаа, төрийн бус байгууллагад олон жил амжилт гарган ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

### ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

- |                       |  |
|-----------------------|--|
| 1. Замбын Батжаргал   | -Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ус, цаг уур, орчны шинжилгээний газрын дарга |
| 2. Осорын Батцэнгэл   | -Монгол тахир дутуу иргэдийн соёл урлагийн үндэсний төвийн тэргүүн                 |
| 3. Сонингийн Бахнаа   | - Нийслэлийн Дашчойлон хийдийн ерөнхий нягтлан бодогч                              |
| 4. Дашнямын Буянхишиг | - Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны мэргэжилтэн                                      |



- |                             |   |
|-----------------------------|---|
| 5. Дэнзэнгийн Гомбодорж     | - Завхан аймгийн шүүхийн шүүгч  |
| 6. Охины Гонсон             | - Засгийн газрын тохируулагч агентлаг-Байгаль орчныг хамгаалах албаны ерөнхий мэргэжилтэн         |
| 7. Түвдэнгийн Данзанлхагва  | - Ховд аймгийн Чандмань сумын хүний эмнэлгийн эрхлэгч, их эмч                                     |
| 8. Гонгорын Даштүдэв        | - Хууль зүйн яамны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга |
| 9. Минжүүрийн Дүгэрсүрэн    | - Техникийн их сургуулийн харьяа Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн багш                |
| 10. Бямбын Жигжид           | - Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Нийтийн аж ахуй, үйлчилгээний газрын дарга                 |
| 11. Галсангийн Зинаамъядар  | - Засгийн газрын тохируулагч агентлаг-Санхүүгийн улсын хяналт шалгалтын газрын дарга              |
| 12. Идэнгийн Лхамсүрэн      | - Нийслэлийн Хан-Уул дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга                  |
| 13. Нацагийн Мэндбаяр       | - Чөлөөт уран бүтээлч, хөгжмийн зохиолч   |
| 14. Балаагийн Нямдорж       | - Дорноговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга                            |
| 15. Данцдарын Өлзий         | - Улсын филармонийн дэргэдэх "Эртний сайхан" чуулгын жүжигчин                                     |
| 16. Жаалын Пүрэв            | - Дундговь аймгийн Сайнцагаан сумын "Дархан" ХЭАА-н эзэн  |
| 17. Нансалын Пүрэвсүрэн     | - Монголын радиогийн редактор, хүүхдийн зохиолч   |
| 18. Гунгаагийн Содномдаржаа | - Нийслэлийн эмийн худалдааны "Асгат трейд" ХХК-ийн ерөнхий захирал                               |
| 19. Ахурын Хөхөө            | - Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн захирал                                       |
| 20. Халтарын Цэрэндаваа     | - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга                                  |
| 21. Очирдолгорын Энхтайван  | - Нийслэлийн Багануур дүүргийн Гэгээрэл, хөгжлийн төвийн дасгалжуулагч                            |

## "АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

- |                              |  |
|------------------------------|--|
| 1. Дэнцэвийн Амгаа           | - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Буурал хаан" ХХК-ийн захирал                                  |
| 2. Мижиддоржийн Аня          | - Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн эх барих, эмэгтэйчүүдийн клиникийн эх баригч, бага эмч      |
| 3. Аюушжавын Баасанжав       | - Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны ахлах мэргэжилтэн  |
| 4. Мишигийн Бадамцэцэг       | - Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны ахлах мэргэжилтэн  |
| 5. Дашзэвэгийн Бадарч        | - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүгч  |
| 6. Ядамсүрэнгийн Базаррагчаа | - Орхон аймгийн үйлчилгээ, аж ахуйн "Нам гэрэл" ХХК-ийн захирал                                    |
| 7. Сүрэнгийн Балжинням       | - Эрдэнэт-Булганы цахилгаан, шугам сүлжээний газрын монтерч  |
| 8. Дамдины Бальдир           | - Монголын байгаль, орчныг хамгаалах холбооны тахь нутагшуулах "Хустай" төвийн байгаль хамгаалагч  |
| 9. Намхайн Банди             | - Монголын байгаль орчныг хамгаалах холбооны тахь нутагшуулах "Хустай" төвийн захирал              |
| 10. Намхайдагвын Банзрагч    | - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга            |
| 11. Рэнцэнгийн Батмэнд       | - Монголын Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ахлах референт                                 |
| 12. Рословын Бат-Эрдэнэ      | - "МИАТ" компанийн нислэгийн аюулгүй байдал хариуцсан тэргүүн дэд захирал                          |
| 13. Рэгзээгийн Бузмаа        | - Нийслэлийн үйлдвэр, үйлчилгээний "Жирээг" ХХК-ийн захирал  |
| 14. Тамжавын Бумцэнд         | - Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ахлах шинжээч                                    |
| 15. Гавиахүүгийн Буянбат     | - Төрийн хянан шалгах хорооны хянан байцаагч   |
| 16. Юндэнгийн Будрагчаа      | - Төр, засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харьяа 30 дугаар буудлын нярав                     |
| 17. Цэндийн Будханд          | - Улсын ерөнхий прокурорын газрын зааварлагч   |
| 18. Соллооны Бямбадорж       | - Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга                                     |
| 19. Олзвойн Ганбаатар        | - Эрдэнэт-Булганы цахилгаан, шугам сүлжээний газрын тээвэр механик хангамж сүлжээний хэсгийн дарга |



- |                                |   |
|--------------------------------|---|
| 20. Сахилтын Гонгор            | - Нийслэлийн Налайх дүүргийн 1 дүгээр хорооны Засаг дарга   |
| 21. Сономын Даваадагва         | - Баянхонгор аймгийн Тээврийн газрын дарга  |
| 22. Цамбын Даваахүү            | - Ховд аймгийн нэгдсэн эмнэлгийн мэс заслын зөвлөх эмч  |
| 23. Намжилын Данаажав          | - Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ахлах референт  |
| 24. Пүрэвийн Дашдаваа          | - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн өндөр настан  |
| 25. Очиржавын Дашням           | - Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтан  |
| 26. Баадайн Довдонбалжир       | - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын албаны хэлтсийн дарга  |
| 27. Ядамын Долгоржав           | - Удирдлагын академийн төрийн удирдлагын тэнхмийн эрхлэгч   |
| 28. Маржаагийн Дуламсүрэн      | - Нийслэлийн 86 дугаар цэцэрлэгийн эрхлэгч  |
| 29. Эрдэнийн Дуламсүрэн        | - Нийслэлийн худалдаа үйлчилгээний "Хэрлэн-Ундарга" нөхөрлөлийн эзэн  |
| 30. Ядамсүрэнгийн Жавзан       | - Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын зохион байгуулагч  |
| 31. Жинжсүрэнгийн Жавзмаа      | - Увс аймгийн Хөгжимт драмын театрын найрал дууны багш  |
| 32. Дугарын Жаргалсайхан       | - Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын дарга   |
| 33. Насанхүүгийн Жигмэд        | - Эрдэнэт-Булганы цахилгаан, шугам сүлжээний газрын цахилгаанчин  |
| 34. Бэгзжавын Жүгдэр           | - Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын референт  |
| 35. Гаагагийн Заанхүү          | - Байгаль орчныг хамгаалах албаны улсын ахлах байцаагч  |
| 36. Эмээлийн Зандаръя          | - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын албаны төв лабораторийн ажилтан  |
| 37. Рэндоогийн Зундуй          | - Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын үйлдвэрлэл, үйлчилгээний "Залуу хүч" ХХК-ийн захирал                                 |
| 38. Даваагийн Лхаашид          | - Удирдлагын академийн удирдахуйн тэнхмийн эрхлэгч  |
| 39. Ядамын Лхагвасүрэн         | - Нийслэлийн нийтийн зорчигч тээврийн "Автобус-3" компани ЛУУГ/ийн дэд захирал  |
| 40. Дамбын Монхор              | - Гэгээрлийн яамны ахлах мэргэжилтэн  |
| 41. Даваасүрэнгийн Нарандэлгэр | - Удирдлагын академийн систем мэдээлэл, технологийн тэнхмийн эрхлэгч  |
| 42. Должингийн Нэргүй          | - Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хөдөө аж ахуйн газрын дарга  |
| 43. Галсандагын Нямдаваа       | - "МИАТ" компанийн ерөнхий захирал  |
| 44. Дагдангийн Пүрэв           | - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Зэл" ХХК-ийн захирал   |
| 45. Чанагийн Пүрэвбанзрагч     | - Нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний "Чин" ХХК-ийн инженерийн албаны дарга   |
| 46. Готовын Пүрэвдорж          | - Эрдэнэт-Булганы цахилгаан, шугам сүлжээний газрын дарга   |
| 47. Хорлоогийн Сайндорж        | - Эрчим хүчний удирдах газрын баазын жолооч   |
| 48. Цэндсүрэнгийн Самбуудорж   | - Нийслэлийн сургууль, цэцэрлэгүүдийн хангамж, засвар үйлчилгээний "Цагаан лавай трейд" компани ЛУУГ/ийн бригадын дарга |
| 49. Намжилын Сумъяа            | - Нийслэлийн тээвэр, үйлчилгээний "Автобус-1" компанийн орлогч захирал  |
| 50. Жамбалын Сундуйжав         | - Төрийн хянан шалгах хорооны ахлах хянан байцаагч  |
| 51. Баасанжавын Тогтохбаяр     | - Улаанбаатар хотын тээвэр зохицуулалтын газрын улсын байцаагч  |
| 52. Намсрайн Төмөрбаатар       | - Нийслэлийн тээвэр, үйлчилгээний "Бид анд" ХХК-ийн захирал   |
| 53. Ёндонгийн Төмөр-Очир       | - Нийслэлийн тээвэр, үйлчилгээний "Автобус-1" компанийн жолооч  |
| 54. Бат-Очирын Тунгалаг        | - Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөө аж ахуйн газрын ерөнхий нягтлан бодогч                                     |
| 55. Адъяагийн Уранчимэг        | - Нийслэлийн Багануур дүүргийн худалдаа, үйлчилгээний "Есөн шанд" ХХК-ийн дэд захирал                                   |
| 56. Гунгаажавын Хаянхирваа     | - Эрдэнэт-Булганы цахилгаан, шугам сүлжээний газрын ахлах инженер   |
| 57. Дамбадаржаагийн Хөхөө      | - Техникийн их сургуулийн Хүнсний технологийн сургуулийн багш   |
| 58. Самбуугийн Цэрэндорж       | - Нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний "Ган зам" ХХК-ийн ерөнхий захирал   |
| 59. Хувьтын Чулуудай           | - Монголын байгаль, орчныг хамгаалах холбооны зөвлөлийн эрхлэгч   |
| 60. Сосорын Шуураа             | - Нийслэлийн Баянгол дүүргийн Тохижилт үйлчилгээний компанийн зам талбайн үйлчлэгч                                      |
| 61. Юндэнгийн Эрдэнэтуяа       | - Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтан  |

6:2. Дагвадоржийн Эрдэнэчимэг  
6:3. Дашдоогийн Ядамбаатар

- Улсын ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор  
- Эрдэнэт-Булганы цахилгаан, шугам сүлжээний газрын ахлах инженер

## ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

- |                               |  |
|-------------------------------|--|
| 1. Нүрээдийн Батбаатар        | - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга                        |
| 2. Осхнойн Батсайхан          | - Үндэсний архивын газрын дарга  |
| 3. Дамдины Баяраа             | - Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шинжээч  |
| 4. Бямбацэрэнгийн Баярсайхан  | - Нийслэлийн тээвэр үйлчилгээний "Автобус-1" компанийн засварчин                                 |
| 5. Чимэддоржийн Бямбадорж     | - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга               |
| 6. Даваагийн Бямбажав         | - Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шинжээч  |
| 7. Сунаравын Ганболд          | - Нийслэлийн Баянгол дүүргийн Биеийн тамир, спорт сургалтын төвийн захирал                       |
| 8. Чадраабалын Дарьсүрэн      | - Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны ахлах мэргэжилтэн  |
| 9. Дүгэрийн Дашхорлоо         | - Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга                          |
| 10. Баадгайн Долгор           | - Нийслэлийн Багануур дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн сувилагч                                   |
| 11. Сэнгээгийн Ичинхорлоо     | - Гэмтэл согог, сэргээн засалтын клиникийн эмнэлгийн ахлах сувилагч                              |
| 12. Далайн Лхамжав            | - Нийслэлийн Баянгол дүүргийн Тохижилт үйлчилгээний компанийн зам талбайн үйлчлэгч               |
| 13. Янжмаагийн Лхамсүрэн      | - Нийслэлийн тээвэр үйлчилгээний "Автобус-1" компанийн нягтлан бодогч                            |
| 14. Дэндэвийн Мөнхсайхан      | - Нийслэлийн Баянгол дүүргийн Тохижилт үйлчилгээний компанийн жолооч                             |
| 15. Дархикавын Надмид         | - Дорноговь аймгийн Замын-Үүд сумын худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний "Ган торх" ХХК-ийн зөвлөх |
| 16. Цагааны Нямхүү            | - Орхон аймгийн Шүүхийн бичээч, бичиг хэргийн эрхлэгч  |
| 17. Цэрэндоржийн Олзхүү       | - Хөвсгөл аймаг дахь Сум дундын шүүхийн шүүх хуралдааны нарийн бичгийн дарга                     |
| 18. Дашцэрэнгийн Отгон        | - Монголын байгаль орчныг хамгаалах холбооны нарийн бичгийн дарга                                |
| 19. Иңоровын Отгонбаяр        | - Хөдөлмөр нийгмийн хамгааллын хяналтын албаны улсын байцаагч                                    |
| 20. Дамбадаржаагийн Пүрэвжав  | - Хөвсгөл аймгийн шүүхийн жолооч   |
| 21. Ёаатархүүгийн Пүрэвсүрэн  | - Увс аймгийн Өндөрхангай сумын Гандандаржаалин хийдийн захирагч                                 |
| 22. Тогтохдоржийн Ренчинноров | - Нийслэлийн Клиникийн нэгдүгээр амаржих газрын эх баригч, бага эмч                              |
| 23. Самбуугийн Сумъяа         | - Төрийн ордны зоогийн газрын ахлах тогтооч  |
| 24. Цэрэнбизъяагийн Сүхбаатар | - Улаанбаатар төмөр замын дохиолол холбоо, эрчим хүчний албаны орлогч дарга                      |
| 25. Равдангийн Тэгшжаргал     | - Төрийн ордны зоогийн газрын тогтооч  |
| 26. Түвдэнгийн Тэгшжаргал     | - Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн ахлах сувилагч   |
| 27. Батын Тэгшээ              | - Сэлэнгэ аймгийн Шүүхийн шүүх хуралдааны нарийн бичгийн дарга                                   |
| 28. Дүгэрдоржийн Цэрэндагва   | - Нийслэлийн тээвэр үйлчилгээний "Автобус-1" компанийн хэсгийн дарга                             |
| 29. Отгоны Чимэд              | - Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 4 дүгээр багийн Засаг дарга  |
| 30. Бямбын Чулуунбат          | - Эрдэнэт-Булганы цахилгаан шугам сүлжээний газрын ерөнхий инженер                               |
| 31. Хяангайн Энхтайван        | - Улаанбаатар төмөр замын Төв эмнэлгийн сувилагч   |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБААНДИ





## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 7 дугаар сарын 17-ны өдөр

Дугаар 114

Улаанбаатар хот

### "Цэргийн цол олгох журам"-ын заалтад өөрчлөлт, нэмэлт оруулах тухай

1. Монгол Улсын ерөнхийлөгчийн 1999 оны 41 дүгээр зарлигийн хавсралт "Цэргийн цол олгох журам"-ын "Дөрөв" дэх хэсгийн 2 дахь заалтын "... бэлтгэл дээд офицерын цолыг ..." гэснийг хасаж, "Монгол Улсын Ерөнхийлөгч дээд офицерын цол бүхий албан тушаалтны цолыг бууруулах, хасах буюу сэргээн олгоно." гэж найруулсугай.

дээд офицерын цолыг хасах бол дээд офицерын цол олгох саналыг өргөн барих эрх бүхий байгууллага, албан тушаалтан дээд офицерын цол бууруулах, хасах тухай саналаа Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барина." гэж нэмэлт оруулсугай.

2. Мөн заалтад "Дээд офицерыг албан тушаалаас чөлөөлж, дээд офицерын цолны зэрэглэлгүй албан тушаалд бууруулан томилох,

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 6 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 89

Улаанбаатар хот

### Зарим орон сууц хувьчлах тухай

Орон сууц хувьчлах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа хувьчлагдах зарим орон сууц"-ны хувьчлалыг 2 дугаар хавсралтад заасны дагуу.

1. Батлан хамгаалах яам болон зэвсэгт хүчин, хилийн цэргийн төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа зарим орон сууцыг Төрийн өмчийн хорооноос зохион байгуулан оршин суугч офицер, ахлагч, тухайн салбарын ажилчин, албан хаагч, цэргийн тэтгэвэрт гарсан ахмадууд, тэдний гэр бүлийнхэнд дор дурдсанаар хувьчлах нь зүйтэй гэж үзсүгэй:

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хувьчлалд үл хамаарах орон сууцны жагсаалт батлах тухай" Засгийн газрын 1998 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 148 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 33-55 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

а/ Батлан хамгаалах яамны эзэмшилд байгаа хувьчлагдах зарим орон сууц"-ны хувьчлалыг 1 дүгээр хавсралтад заасны дагуу;

**Монгол Улсын Ерөнхий  
сайд**

**Р.АМАРЖАРГАЛ**

б/ Зэвсэгт хүчин, хилийн цэргийн

**Сангийн сайд**

**Я.ОЧИРСҮХ**

**Батлан хамгаалахын  
сайд**

**Ш.ТҮВДЭНДОРЖ**

*Засгийн газрын 2000 оны 89 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт*

### БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ЭЗЭМШИЛД БАЙГАА ХУВЬЧЛАГДАХ ОРОН СУУЦ

№	Орон сууцны				Сууцны тоо	Үүнээс Хувьчлагдах	Сууцны харьяалал
	Эзэмшигч байгууллагын нэр	Барилгын нэр	Барилгын байршил	Ашиглалтад орсон он			
1.	Зэвсэгт хүчний 120 дугаар анги	Угсармал орон сууц №7	Нийслэлийн Сонгино-хайрхан дүүрэг, XX хороо, Толгойт	1992	58	58	Батлан хамгаалах яам
2.	Зэвсэгт хүчний 124 дүгээр анги	Мөн сууц №9	-.-	1993	58	58	-.-

3.	Зэвсэгт хүчний 028, 311 дүгээр анги	Мөн сууц №3	--	1993	58	58	--
4.	Зэвсэгт хүчний 013 дугаар анги	Мөн сууц №4	--	1992	58	58	--
5.	Зэвсэгт хүчний 019, 122 дугаар анги	Мөн сууц №6	--	1992	29	29	--
6.	Мөн ангид	Мөн сууц №8	--	1992	29	29	--
7.	Зэвсэгт хүчний 016 дугаар анги	Мөн сууц №2	--	1996	29	29	--
8.	Зэвсэгт хүчний 165 дугаар анги	Мөн сууц №6А	Нийслэлийн Баянгол дүүрэг, П хороолол	1995	59	59	--
9.	Нийслэлийн Зэвсэгт хүчний орон сууц, нийтийн аж ахуй, үйлчилгээний анги	Мөн сууц №27	Нийслэлийн Баянзүрх дүүрэг, ХҮ1 хороолол	1995	70	58	Батлан хамгаалах ям, Арьс ширний нэгдэл
10.	Мөн анги	Мөн сууц №25	--	1993	72	63	БХЯ
11.	Мөн анги	Мөн сууц №26	--	1992	72	72	--
12.	Мөн анги	Тоосгон орон сууц, 2 дугаар 80 айл	Мөн дүүргийн 19 дүгээр хороо, Шар хад	1967	80	80	--
13.	Мөн анги	Тоосгон сууц, №21	Нийслэлийн Баянзүрх дүүргийн ХҮ1 хороолол	1959	36	36	--
14.	Мөн анги	Мөн сууц №22	--	1959	36	36	--
15.	Зэвсэгт хүчний 228 дугаар анги	Мөн сууц №1	Мөн дүүргийн Х хороо, Улиастай	1967	12	12	--
16.	Мөн анги	Мөн сууц №2	--	1967	12	12	--
17.	Мөн анги	Мөн сууц №3	--	1967	12	12	--
18.	Зэвсэгт хүчний 124 дүгээр анги	Угсармал модон сууц №10	Нийслэлийн Баянзүрх дүүргийн 37 дугаар хороо, Сансар	1980	13	13	--
19.	Зэвсэгт хүчний 124 дүгээр анги	Угсармал модон сууц №9	Нийслэлийн Баянзүрх дүүргийн 37 дугаар хороо, Сансар	1967	12	12	БХЯ
20.	Мөн анги	Мөн сууц №8	--	1967	12	12	--
21.	Мөн анги	Мөн сууц №7	--	1968	12	12	--
22.	Мөн анги	Мөн сууц №5	--	1967	12	12	--
23.	Мөн анги	Мөн сууц №4	--	1968	12	12	--

Засгийн газрын 2000 оны 89 дүгээр  
тогтоолын 2 дугаар хавсралт

## ЗЭВСЭГТ ХУЧИН, ХИЛИЙН ЦЭРГИЙН ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭЗЭМШИЛД БАЙГАА ХУВЬЧЛАХ ЗАРИМ ОРОН СУУЦ

№	О р о н с у у ц н ы				Нийт орон сууцны тоо	Үүнээс Хувьчлагдах	Сууцны харьяалал
	Зэмшигч байгууллагын нэр	Барилгын нэр	Барилгын байршил	Ашиглалтад орсон он			
1.	Нийслэлийн Зэвсэгт хүчний орон сууц, нийтийн аж ахуй, үйлчилгээний анги	Угсармал орон сууц №24	Нийслэлийн Баянзүрх дүүрэг, ХҮ1 хороолол	1997	72	71	БХЯ
2.	-.-	Мөн сууц №1	Нийслэлийн Сонгинохайр-хан дүүрэг, XX хороо, Толгойт	1998	59	59	БХЯ, СЯ, ХЦУГ
3.	Зэвсэгт хүчний 124 дүгээр анги	Угсармал модон сууц №6	Нийслэлийн Баянзүрх дүүрэг, 37 дугаар хороо, Сансар	1967	6	6	БХЯ
4.	Барилгын цэргийн 022 дугаар анги	8 айлын сууц №1	Нийслэлийн Сонгинохайр-хан дүүрэг, XX хороо, Толгойт	1983	8	8	Зэвсэгт хүчний ерөнхий штабын Барилгын цэргийг удирдах газар
5.	Мөн анги	Мөн сууц №4	-.-	1983	8	8	-.-
6.	Мөн анги	Мөн сууц №7	-.-	1983	8	8	-.-
7.	Мөн анги	Мөн сууц №12	-.-	1983	8	8	-.-
8.	Барилгын цэргийн 073 дугаар анги	Мөн сууц №5	-.-	1983	8	8	-.-
9.	Барилгын цэргийн 158 дугаар анги	Мөн сууц №2	-.-	1983	8	8	-.-
10.	Барилгын цэргийн 182 дугаар анги	Мөн сууц №3	-.-	1983	8	8	-.-
11.	Мөн анги	Мөн сууц №8	-.-	1983	8	8	-.-
12.	Мөн анги	Мөн сууц №11	-.-	1983	8	8	-.-
13.	Барилгын цэргийн 047 дугаар анги	Мөн сууц №9	-.-	1983	8	8	-.-
14.	Мөн анги	4 айлын сууцны 1-13 дугаартай байрууд	Нийслэлийн Баянзүрх дүүрэг, X хороо, Амгалан	1983	52	52	-.-
15.	Барилгын цэргийн 158 дугаар анги	Тоосгон байшин №5	Нийслэлийн Баянгол дүүрэг, П хороо	1964	50	50	-.-
16.	Барилгын цэргийн Засвар механикийн завод	8 айлын сууц №6	Нийслэлийн Сонгинохайр-хан дүүрэг, XX хороо, Толгойт	1983	8	8	-.-
17.	Хилийн цэргийн 0288 дугаар анги	58 айлын сууц	Нийслэлийн Баянзүрх дүүрэг, ХҮ1 хороо, цэргийн 72 дугаар хотхон	1978	58	51	ХЦУГ



18.	Мөн анги	60 айлын сууц	-.	1978	60	43	-.
19.	Мөн анги	Мөн сууц	-.	1978	60	43	-.
20.	Мөн анги	4 айлын сууц	-.	1978	4	4	-.
21.	Мөн анги	1 айлын сууц	-.	1978	1	1	-.
22.	Мөн анги	32-ын "а" байр	Нийслэлийн Сүхбаатар дүүрэг, Х хороо, 100 айл	1992	32	23	-.
23.	Мөн анги	34 дүгээр байр	-.	1996	38	26	-.
24.	Хилийн цэргийн 0119 дүгээр анги	24 айлын сууц	Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг, Y хороо, Толгойт	1997	24	24	-.
25.	Мөн анги	9 айлын сууц	Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг, YI хороо, Баянхошуу	1997	9	9	-.
25.	Хилийн цэргийн 0288 дугаар анги	8 айлын 2 байр	Нийслэлийн Баянзүрх дүүрэг, YШ хороо, Амгалан	1976	16	16	-.
27.	Мөн анги	4 айлын 6 байр	-.	1980	24	24	-.
28.	Хилийн цэргийн 0151 дүгээр анги	20 айлын сууц	Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг, XX хороо, Толгойт	1998	20	20	-.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 6 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 90

Улаанбаатар хот

### Гэгээрлийн салбарын зарим байгууллагын менежментийг гэрээгээр гүйцэтгүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Худалдаа, үйлдвэрлэлийн дээд сургууль, Хүнсний технологийн сургууль, "Монгол кино нэгтгэл" улсын үйлдвэрийн газрын менежментийг гэрээгээр гүйцэтгүүлэх туршилтад хамруулахыг Гэгээрлийн сайд А.Баттөрд зөвшөөрсүгэй.

2.Худалдаа, үйлдвэрлэлийн дээд сургууль, Хүнсний технологийн сургууль, "Монгол кино нэгтгэл" улсын үйлдвэрийн газрын менежментийг

гэрээгээр гүйцэтгүүлэх туршилтад хамруулах тендерийн хөтөлбөр, болзлыг боловсруулж, хэрэгжүүлэхийг Гэгээрлийн сайд А.Баттөр, Сангийн сайд Я.Очирсүх, Төрийн өмчийн хорооны дарга Д.Зоригт нарт даалгасугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд**

**Р.АМАРЖАРГАЛ**

**Сангийн сайд**

**Я.ОЧИРСҮХ**

**Гэгээрлийн сайд**

**А.БАТТӨР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 6 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 93

Улаанбаатар хот

### Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих Үндэсний хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих Үндэсний хөтөлбөрийг хавсралтын ёсоор баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохицуулалтыг улс, орон нутгийн хэмжээнд хангах үүрэг бүхий Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих Үндэсний хороог Ерөнхий сайдаар, аймаг, нийслэл, сум, дүүргийн зөвлөлийг тухайн шатны Засаг даргаар ахлуулан тус тус байгуулсугай.

3.Хөтөлбөрийн хэрэгжилтийг мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих Үндэсний хорооны ажлын албаны чиг үүргийг гүйцэтгэх Өрхийн амьжиргааг дэмжих хөтөлбөрийн газрыг Ядуурлыг бууруулах хөтөлбөрийн газрын боловсон хүчний нөөц, материаллаг бааз дээр тулгуурлан байгуулж ажиллуулсугай.

4.Сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт

даалгах нь:

а/Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусган, биелэлтийг хангаж ажилласугай;

б/Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх талаар гадаад орон, олон улсын байгууллагатай идэвхтэй хамтын ажиллагаа өрнүүлж, хөгжлийн албан ёсны тусламж, урт хугацааны хөнгөлөлттэй зээл, хандивын эх үүсвэр олох талаар санаачилгатай ажилласугай.

5.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг жил бүрийн 6 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд С.Сонинд даалгасугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд**
**Р.АМАРЖАРГАЛ**

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд

**С.СОНИН**
*Засгийн газрын 2000 оны 93 дугаар тогтоолын хавсралт*

### ӨРХИЙН АМЬЖИРГААНЫ ЧАДАВХИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

#### Нэг.Нийтлэг үндэслэл

1.Амьжиргааны өнөөгийн байдал, тулгамдсан асуудал

Үндэсний статистикийн газраас 1998 онд явуулсан хүн амын амьжиргааны түвшний түүвэр судалгааны дүнгээр ядуу, нэн ядуу амьдралтай 849,0 мянган хүн байгаа нь 1995 оныхоос 2,6 хувь буюу 21,8 мянган хүнээр нэмэгдэж, нийт хүн амын 36 хувийг эзэлж байна. Түүнчлэн ядуурлын ирмэгт байгаа амьдралын чадавхи сул иргэд хүн амын 26 хувийг эзэлж байгаа нь нийт хүн амын 60 орчим хувь нь амьдралын чадавхи сул, ядуу, нэн ядуу түвшинд амьдарч байна гэсэн үг юм.

#### Хүн амын амьжиргааны түвшин

№	Амьжиргааны түвшин	Хүн амд эзлэх хувь
1	Амьдралын чадавхи сайтай	16
2	Амьдралын чадавхи дунд	22
3	Амьдралын чадавхи сул	26
4	Ядуу	16
5	Нэн ядуу	20
	Дүн	100

/Хүн амын амьжиргааны түвшний түүвэр судалгаа 1998 он/

Улсын хэмжээгээр хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлт 64,4 хувь байхад эмзэг



бүлгийн хүн амын хөдөлмөр эрхлэлт 37,6-48,3 хувь байгаа нь улсын дунджаас 16,7-27,4 пунктээр доогуур байна.

Ядуурал, ажилгүйдлийн 1999 оны улсын үзлэгийн дүнгээр ядуу хүн амын 44,8 хувь нь хөдөлмөрийн насны хүн ам, үүнээс 42 хувь нь ажилтай, 48 хувь нь ажилгүй, 4 хувь нь хөдөлмөрийн чадваргүй, 6 хувь нь суралцагсад байна.

Хөдөлмөр эрхэлдэггүй ядуу хүмүүсийн 56 хувь нь огт мэргэжилгүй байна.

Хөдөлмөр эрхэлдэг ядуу хүмүүсийн 20 орчим хувь нь төсвийн байгууллагад, 10 хувь нь төрийн өмчийн бусад байгууллагад, 25 шахам хувь нь хувийн хэвшилд тус тус хамрагдаж байгаа бөгөөд 47 хувь нь ардын аж ахуйтнууд байна.

Хэдийгээр төсвийн байгууллагын ажиллагсдын дундаж цалингийн хэмжээ 50000 төгрөгт хүрсэн ч энэ нь өнөөгийн хэрэглээний шаардлагын түвшинд хүрч, тэдний ам бүлийг тэжээж, ядуурлаас хамгаалах хэрэгсэл болж хараахан чадахгүй байна.

Ядуу хүмүүсийн эрүүл мэндийн байдал илт доройтож өвчлөлд өртөх эрсдэл нь ихэссээр байна. Ялангуяа халдварт өвчнөөр өвчлөгсдийн дотор эмзэг бүлгийн хүн амын эзлэх хувь жилээс жилд өсч байна.

Амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой өрхийн иргэд хоол хүнсний байнгын хомсдолд орж, өлмөн зэлмэн байдалд аж төрж байна. Монгол хүний өдөрт хэрэглэх хоол тэжээлийн илчлэгийн зохистой нормыг 2900 калори гэж тогтоосон бол ядуу өрхийн гишүүд өдөрт дунджаар 1784 калори авч байна. Эмзэг бүлгийн өрхийн амьжиргааны өнөөгийн байдал нь "ядуурал-өлсгөлөн-өвчин" гэсэн гинжин холбоог үүсгэж байна.

Ядуу амьдралтай өрхийн хүүхдүүдэд боловсрол олгох, мэргэжил эзэмшүүлэхэд ихээхэн бэрхшээл учирч байна.

Ядуурлын улмаас хүүхдийнхээ хувцас, хичээлийн хэрэгсэл худалдан авч

чадахгүй байгаа өрхийн тоо өсч, хөдөө орон нутагт ядуу өрх хүүхдийнхээ байр, хоолны зардлыг төлж чадахгүй болсон зэрэг нь сургууль завсардалт нэмэгдэхэд нөлөөлж байна.

1994-2000 онд тус улсад анх удаа Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг төвлөрлийг сааруулах зарчим, олон нийтийн оролцоонд тулгуурлан гадаад орон, олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлснээр нийгмийн амьдралд шилжилтийн үеийн сөрөг үр дагавар болон гарч ирсэн ядуурлын асуудлыг бодлогын хэмжээнд тодорхойлж, чиглэсэн зорилго, зорилт бүхий үйл ажиллагааг явуулах, ядуу хүмүүсийн гутранги сэтгэл зүйг өөрчилж хийж бүтээснээрээ амьдралаа өөрөө өөд нь татах үзэл бодлыг төлөвшүүлэхэд зэрэг нөлөө үзүүлж, ядуурлыг бууруулж, түүнийг газар авахуулахгүй байхын төлөө үйлсэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн анхаарал, хүчийг төвлөрүүлж өгсөн юм.

Гэвч ядуурлыг бууруулахад чиглэсэн төрийн байгууллагын бодлого, үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, мэдээлэл, сурталчилгаа, сургалт, судалгааны нэгдсэн тогтолцоо бий болгох, ядуу хүмүүсийг амьдрах арга ухаанд сургаж, мэргэжил, үр чадвар эзэмшүүлэх, ядуурлыг бууруулах сангаас олгосон зээлийн үр дүн, эргэн төлөлтийг тооцох хяналтыг сайжруулах талаар дутуу анхаарснаас уг хөтөлбөрийн хэрэгжилтийн явц саарч, хүлээсэн үр дүнд хүрч чадаагүй нь дараагийн шатны ажилд томоохон сургаж болж байна.

Иймд 1994-2000 онд хэрэгжсэн Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны дараагийн шатны үргэлжлэл болох Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөр /цаашид "хөтөлбөр" гэх/-ийг Засгийн газраас батлан гаргаж байна.



## Хоёр.Хөтөлбөрийн үндсэн зорилго, зарчим

2.Хүний хөгжлийн хүчин зүйл, чадавхийг дэмжин хөгжүүлэхэд шаардагдах эдийн засаг, нийгмийн зайлшгүй үйлчилгээний хүрээг өргөжүүлэх замаар амьжиргааны доод түвшнээс бага орлоготой өрхийн амьжиргааг сайжруулах, ядуурлын ирмэгт байгаа өрхийг ядууралд орохоос урьдчилан сэргийлэх нь хөтөлбөрийн үндсэн зорилго юм.

3.Хөтөлбөрийг дор дурдсан үндсэн зарчим дээр тулгуурлан хэрэгжүүлнэ:

а/хот, хөдөө, хүн амын бүлгийн болон өрхийн онцлог байдалд тохирсон ядуурлыг бууруулах ялгавартай бодлого, арга хэмжээ авах;

б/өмчийн бүх хэвшлийн байгууллага, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, тэдгээрийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах;

в/хөрөнгийн зарцуулалт, бүрдүүлэлтэд орон нутгийн оролцоог эрчимжүүлж, төвлөрлийг сааруулах;

г/хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг улс, орон нутгийн хөгжлийн бодлого, бусад хөтөлбөрүүдтэй уялдуулан зохицуулах;

д/санхүүгийн эх үүсвэр, зээлийн хөрөнгийг хүртээмжтэй, үр ашигтайгаар урамшуулан хуваарилах;

е/жендерийн асуудлыг харгалзах;

ж/үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, мэдээллийн урсгалыг сайжруулах.

**Гурав.Хөтөлбөрийн хамрах хүрээ,үйл ажиллагааны үндсэн чиглэл, зорилт**

## А.Нийгмийн хүрээ

4.Эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах талаар шийдвэрлэх зорилт:

Эрүүл мэндийн үйлчилгээний болон эм хангамжийн хүртээмж, чанарыг сайжруулан, алслагдсан орон нутагт хүрч үйлчлэх боломжийг нэмэгдүүлснээр эх, нялхсын эндэгдэл, халдварт өвчний гаралтыг бууруулахад нөлөөлнө.

5.Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/сумын эмнэлэг, эхчүүдийн төрөхийн өмнөх байрыг засварлах, тохижуулах, халаалт, цахилгааны эх үүсвэрийн асуудлыг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх;

б/багийн болон өрхийн эмч нарыг унаа, эмнэлгийн анхны тусламжийн эм, багаж хэрэгслээр хангахад дэмжлэг үзүүлэх;

в/баг, өрхийн эмчээс өрх бүрт хүрч үйлчлэх үйл ажиллагааг бүх талаар дэмжиж туслах;

г/5 хүртэл насны хүүхдийн хоол тэжээлийн хангамж, бүтцийн чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.

6.Боловсролын хамрах хүрээг өргөжүүлэх талаар шийдвэрлэх зорилт:

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тогтолцоог бэхжүүлэх, түүнд хамрагдах ядуу өрхийн хүүхдийн тоог нэмэгдүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад амьдрах арга ухаан, бизнесийн мэдлэг олгоход дэмжлэг үзүүлнэ.

7.Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/амьжиргааны доод түвшингээс бага орлоготой өрхийн сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтыг нэмэгдүүлэхэд туслах;



б/тахир дутуу хүүхдийг цэцэррлэг, сургуульд хамруулах, ердийн хүүхэдтэй хамт сурч хүмүүжих нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

в/малчдын хүүхдийг сургуульд бэлтгэх, тэднийг хөгжүүлэх чиглэлээр богино хугацааны төвлөрсөн бэлтгэл сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

г/нэн ядуу амьдралтай өрхийн сургуулийн насны хүүхдийг хувцас, хичээлийн хэрэгслээр хангахад туслах;

д/сургууль завсардсан хүүхдүүдэд нөхөн боловсрол олгох бүх хэлбэрийг дэмжин, хичээлийн болон дотуур байрыг засварлах, халаалт, цахилгааны эх үүсвэрийг шийдвэрлэх, багийн сургууль зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

е/амьдрах арга ухаан, бизнес, зах зээлийн мэдлэг олгох нийтийг хамарсан сургалт явуулах нөхцөл бүрдүүлэхэд туслах;

ж/сургуулийн туслах аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг өгөх;

8.Ахмад настнуудын мэдлэг, чадвар, ажил : амьдралын туршлагыг үр өгөөжтэй ашиглах талаар шийдвэрлэх зорилт:

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ахмадын байгууллага болон өндөр мэдлэг чадвартай, ажил амьдралын туршлагатай ахмадуудыг өргөнөөр оролцуулж, тэдний туршлага, ардын уламжлалт ёс заншлыг айл өрхүүдэд өвлүүлнэ.

## 9.Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/орон нутгийн мэдээлэл, сургалт, судалгаа, сурталчилгааны төвүүдэд ахмадуудыг өөрсдийнх нь хүсэл, сонирхлын дагуу сонгон шалгаруулж ажиллуулах;

б/мэргэжил, ур чадвар эзэмшүүлэх, хууль эрх зүй, амьдрах арга

ухааны сургалт зохион байгуулахад ахмадуудыг өргөнөөр оролцуулах;

в/өндөр мэргэжил, ажлын дадлага туршлагатай ахмадуудыг тодорхой болзол, гэрээгээр халамжлан хүмүүжүүлэгч буюу зөвлөхөөр ажиллуулах хөдөлгөөнийг өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудад өрнүүлэх.

## Б.Эдийн засгийн хүрээ

10.Ажлын байр бий болгох талаар шийдвэрлэх зорилт:

Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай ажилгүй иргэдэд ажлын байр, орлогын байнгын эх үүсвэр бий болгож, бизнесийн үйл ажиллагаа тасралтгүй явуулах боломжийг бүрдүүлнэ.

## 11.Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/амьжиргааны түвшингээс доогуур орлоготой, хөдөлмөрийн чадвартай болон тахир дутуу иргэдэд зориулсан байнгын ажлын байр бий болгоход тусалцаа үзүүлэх;

б/сумдад соёл, ахуйн үйлчилгээний цэг, салбарыг сэргээх, шинээр зохион байгуулах замаар ажлын байр бий болгох асуудлыг шийдвэрлэхэд туслах;

в/Засгийн газраас тэргүүлэх ач холбогдол өгсөн салбарт хийгдэх хөдөлмөр зарцуулалт ихтэй, цаг үеийн шинж чанартай богино хугацааны нийтийг хамарсан ажлыг дэмжихэд чиглэсэн түр ажлын байр олноор бий болгох;

г/орон нутгийн эрэлт хэрэгцээг хангах жижиг бизнесийг төрөл бүрийн хэлбэрээр хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

12.Жижиг зээлийн үйлчилгээг хөгжүүлж иргэдийн хувиараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар шийдвэрлэх зорилт:





Орон нутагт мөнгөний эргэлтийг сайжруулах, жижиг үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, иргэд хувиараа хөдөлмөр эрхлэх, зээл, санхүүгийн дэмжлэг авах боломжийг нэмэгдүүлнэ.

### 13.Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/жижиг зээлийг үе шаттайгаар, тодорхой урамшуулагч хөшүүрэгтэйгээр хэрэгжүүлэх;

б / з э э л и й н эргэлтийн сан бий болгох, түүнийг эрсдэлээс хамгаалах;

в / х а д г а л а м ж зээлийн хоршоо, дундын сан байгуулах санал, санаачилгыг дэмжиж өрнүүлэх;

г / б а р ь ц а а л а н зээлдүүлэх үйлчилгээг өргөжүүлэхэд туслах.

14.Огт малгүй буюу цөөн малтай өрхийг малжуулах талаар шийдвэрлэх зорилт:

Амьжиргааны доод түвшингээс бага орлоготой огт малгүй буюу цөөн малтай иргэдийг мал маллагааны арга барилд сургаж малжуулна.

### 15.Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/олон малтай / мянгат малчин гэх мэт/ айл өрхтэй гэрээ байгуулан ядуу иргэдийг туслах малчнаар ажиллуулах, багш шавийн барилдлагаа бий болгох арга хэлбэрийг хөгжүүлэн дэмжих;

б / т о д о р х о й нөхцөл, болзлын үндсэн дээр цөөн малтай айл өрхийг малжуулах үйл ажиллагаанд өргөнөөр хамруулах;

в/огт малгүй ядуу өрхөд мал худалдан авч өгч, гэрээгээр, тодорхой хугацаатайгаар үр төлөөр нь малжуулах арга хэмжээ авах.

В.Байгаль орчны хүрээ  
16.Байгаль орчны хүрээнд шийдвэрлэх зорилт:

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх замаар өрх бүр эрүүл орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

### 17.Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/худаг, булаг, шандны усыг бохирдлоос хамгаалахад малчид өөрсдөө болон мэргэжлийн хүмүүстэй хамтран ажиллах тогтолцоог бүрдүүлэх;

б/ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад хөдөлмөрийн дадлага эзэмшүүлэх сургалтыг хот, суурин газрыг тохижуулах хөдөлгөөнтэй холбон хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

в/шатсан ойг цэвэрлэж түлшний мод бэлтгэх, мод, бут, сөөг тарих замаар түүнийг нөхөн сэргээх, цөлжилтөөс хамгаалах зэрэг үйл ажиллагаа явуулах байгууллага, иргэдийн санал санаачилгыг дэмжих;

г/хот, суурин газрын агаар, орчны бохирдлыг бууруулах, хог хаягдлыг устгах, дахин боловсруулах үйл ажиллагааг дэмжин туслах;

д/байгаль орчинтой зүй зохистой харьцах, хамгаалах, байгаль орчинд хохирол учруулахгүйгээр өрхийн амьжиргаагаа сайжруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийн санал, санаачилгыг дэмжин бодит туслацгаа үзүүлэхийн зэрэгцээ туршлагыг нь нэвтрүүлэх талаар сургалт, сурталчилгаа өргөнөөр зохион байгуулах.

### Г.Мэдээлэл, судалгаа, сургалт, сурталчилгааны хүрээ

18.Өрхийн амьжиргааны мэдээллийн сүлжээг бий болгох талаар шийдвэрлэх зорилт:



Төр, засгийн бодлого, хөтөлбөрүүдийн өрх, жүн амын амьжиргаанд нөлөөлж буй байдлыг үнэлж дүгнэх, амьжиргааны түвшний өөрчлөлтөд судалгаа хийж мэдээллээр хангаж тогтолцоо бүрдүүлнэ.

а/орон нутагт мэдээлэл, сургалт, судалгаа, сурталчилгааны төвүүдийг бий болгон ажиллуулахад онцгой ач холбогдол өгч, дэмжлэг үзүүлэх;

## 19.Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/удирдлагын мэдээлэл, судалгааны бие даасан нэгж /төв/ийг байгуулах, нийгмийн хамгааллын мэдээллийн сүлжээнд тулгуурласан мэдээллийн төвийг орон нутагт бий болгох;

б/орон нутгийн түвшинд сургалтын эрэлт хэрэгцээг тодорхойлох, ажлын байрны эрэлт, хэрэгцээтэй уялдуулан мэргэжлийн сургалт явуулах;

б/орон нутагт ядууралд орсон болон орж болзошгүй өрхийн социологийн судалгаа явуулах;

в/мэргэжлийн сургалт зохион байгуулах арга зүйг боловсронгуй болгож, мэргэжлийн сургалт удирдан явуулах багшлах боловсон хүчнийг давтан болон шинээр бэлтгэх;

в/хөтөлбөрийн хүрээнд болон хөтөлбөртэй холбоотой чиглэлүүдээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, буяны байгууллага, иргэдийн талаархи мэдээллүүдийг нэгтгэн сурталчилах, түүнд хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, интернетийн сүлжээг ашиглах;

г/иргэдийн хууль эрх зүйн болон техник, технологи, эдийн засгийн боловсролыг дээшлүүлэх;

г/хууль тогтоомжийн талаархи сурталчилгааг тогтмолжуулж, байгууллага, иргэдийг хэрэгцээт гарын авлага, материалаар хангах;

д/мэргэжлийн богино хугацааны болон амьдрах арга ухааны сургалтуудыг зохион байгуулах чадвартай аж ахуйн нэгж, байгууллага, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүд, төрийн бус байгууллагуудын материаллаг баазыг түшиглүүлэн сургалт явуулах, материаллаг баазыг нь бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

## Дөрөв.Олон нийтийн оролцоо

д / з э э л и й н эргэлтийн сангийн байдалд хяналт тавих, тухайн үеийн бодит байдлыг тодорхойлох, үнэлгээ хийх, тогтмол үнэн зөв мэдээллээр хангах.

22.Өрхийн амьжиргааны чадавхийг дээшлүүлэхэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх талаар шийдвэрлэх зорилт:

20.Амьдрах арга ухааны болон мэргэжлийн богино хугацааны сургалтын талаар шийдвэрлэх зорилт:

Өрхийн амьжиргааны чадавхийг сайжруулах, ядуурлыг бууруулах үйл хэрэгт олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх замаар дотоод нөөц бололцоогоо илрүүлэн бүрэн ашиглаж, өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, буяны байгууллага, иргэдийн санаачилга, үйл ажиллагааг дэмжиж эрчимжүүлнэ.

Амьжиргааны доод түвшингээс бага орлоготой, хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэдэд амьдрах арга ухааны үндсэн мэдлэг болон тусгай мэргэжил олгох, дээшлүүлэх, богино хугацааны сургалт зохион байгуулна.

23.Өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудын үүрэг, оролцоо:

## 21.Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/үйлдвэрлэлээ



өргөтгөж, ажлын байр нэмэгдүүлэх талаар аж ахуйн нэгж, байгууллагаас санаачилга гаргах;

**б/ажиллагсдын**  
нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор үйлдвэрлэлийн ашгаас нийгмийн хөгжлийн сан, цэцэрлэг, ясли, амралт сувилал байгуулах, туслах аж ахуй хөгжүүлэх, орон сууц барих хөдөлгөөнийг аж ахуйн нэгжүүдэд өрнүүлэх;

**в/ажиллагсдын**  
мэдлэг, боловсролын түвшин, мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэхэд байнга анхаарах, давтан сургах, мэргэшүүлэх;

**г/ажиллагсдын**  
хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлд онцгой анхаарах, тэднийг эрүүл мэндийн болон бусад даатгалуудад бүрэн хамруулах;

**д/хөдөлмөрийн**  
хуулийн хэрэгжилтийг үйл ажиллагаандаа нарийн чанд мөрдөх, ялангуяа тахир дутуу хүмүүст ажлын байр бий болгох, Үйлдвэрчний эвлэлийн байгууллагаас гаргасан санаачилгыг дэмжиж, идэвхтэй хамтран ажиллах;

**е/сул чөлөөтэй**  
ажлын байранд амьжиргааны доод түвшингээс бага орлоготой иргэдийг авч ажиллуулах санаачилга гарган тэдний амьжиргааг дээшлүүлэх талаар бодит туслалцаа үзүүлэх, авсан арга хэмжээний үр дүнг нийтэд мэдээлж сурталчилгах.

## 24.Төрийн бус байгууллагуудын оролцоо:

**а/амьжиргааны**  
доод түвшингээс доогуур орлоготой өрхийн гишүүдийг нийгмээс асруулагчид биш улс орныхоо эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах чадвартай болгоход чиглэсэн үйл ажиллагаа явуулах, амьдрах арга ухаан, хөдөлмөр эрхлэх арга барилд сургах сургалтууд зохион байгуулах;

**б/иргэдийг зээл**  
тусламжид хамрагдах, хөдөлмөр эрхлэхэд нь

туслах, зуучлах, тэдэнд зөвлөлгөө өгөх, туслалцаа үзүүлэх;

**в/олон нийтийн**  
санаа бодлыг судлах, эрэлт хэрэгцээг тодорхойлох арга хэмжээ авах, өрхийг дэмжих чиглэлийн төсөл боловсруулж хэрэгжүүлэх талаар санаачилга гаргах;

**г/Засгийн газар,**  
төрийн бус байгууллагуудын түншлэлийг өргөжүүлж нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг нэмэгдүүлэх, хүний хөгжлийг тэтгэхэд чиглэсэн төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад сонгон шалгаруулалтаар шилжүүлэх, гэрээгээр гүйцэтгүүлэх хэлбэрийг үр бүтээлтэй ашиглах.

25.Үндэсний шашны болон буяны байгууллагын оролцоог төрөөс дэмжих үйл ажиллагаа:

**а / ш а ш н ы**  
байгууллагуудаас иргэдэд өөрийгөө дайчлах, амьдралын бэрхшээлийг даван туулах талаар үзүүлж байгаа оюун санааны дэмжлэг, ариусал, буруу нүгэлт үйлээс урьдчилан сэргийлэх, амьдрах итгэл нэмэгдүүлэх, өөдрөг, шударга нийгэмч сэтгэлгээг төлөвшүүлэх чиглэлийн үйл ажиллагааг төрөөс сайшаан дэмжих;

**б/сүм хийдүүд,**  
буяны байгууллагаас ядууст зориулсан буяны хишиг өдөртэй болох, бусад халамжийн үйлчилгээ үзүүлэх санаачилгыг дэмжих;

**в/ядуу хүмүүст**  
туслах, тэднийг дэмжих асуудалд амьдралын чадавхи сайтай, чинээлэг хэсгийнхний анхаарлыг хандуулах талаар дээрх байгууллагаас зохиох үйл ажиллагааг дэмжих;

**г/төрийн үйл**  
ажиллагааг дэмжих талаар шашны болон буяны байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнгийн талаар мэдээлэх, олон түмэнд сурталчилгах.

26. Айл өрх, иргэдийн оролцоо:

а/чинээлэг айл өрхүүд ажил эрхлээгүй иргэдтэй гэрээ байгуулан ажил гүйцэтгүүлэх /мал маллуулах, хашаа, байшин бариулах, хадлан, тэжээл бэлтгүүлэх, малын ашиг шим, түүхийг эд ашиглах, боловсруулах, туслах аж ахуйд ажиллуулах, орцны жижүүр манаа хийлгэж, гэрийн ажилд туслуулах, хүүхэд асруулах, сурагчдын хичээл давтуулах, засвар үйлчилгээ хийлгэх, ачаа бараа татуулах, буулгах гэх мэт/ санаачилгыг дэмжих;

б/енчин, тэнэмэл хүүхдэд халамж, тусалцаа үзүүлэх, тэдгээр хүүхдийн эрхийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх;

в/үр хүүхэддээ байнга анхаарал халамж тавьж, тэдэнд ажил, хөдөлмөр эрхлэх идэвх, сонирхлыг төлөвшүүлэн, амьдрах арга ухаанд сургаж, сурч боловсрох, мэдлэг мэргэжил эзэмших нөхцөл бололцоогоор хангах;

г/баг, хороо, сумын хэмжээнд өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих хөдөлгөөн өрнүүлэх, ядуу өрхийг малжуулах, үйлчилгээ эрхлүүлэх, хандив, тусламж үзүүлэх талаар бодлого гарган хэрэгжүүлэх, хийсэн ажлын үр дүнг дүгнэж, цаашдын зорилгыг тодорхойлох, өрхийн чуулга уулзалт зохион байгуулж хэвших;

д/Засгийн газраас явуулж буй бодлого, хөтөлбөртэй танилцах, тэдгээрт хамрагдах, ажиллах саналаа хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгүүлэх, төсөл боловсруулан зээл авч хэрэгжүүлэх, мэдлэг боловсролоо дээшлүүлэх, суралцах, эрүүл мэндээ даатгуулах, хувиараа хөдөлмөр эрхлэх зэргээр өрхийн амьдралаа сайжруулахын төлөө бүтээлчээр идэвхийлэн ажиллаж;

е/өрхийн бий

болгож байгаа ажлын байрны талаархи мэдээллийг статистик мэдээлэлд оруулах;

ж/ардын аж ахуйтнууд фермерийн аж ахуй болон өргөжих;

з / Н о г о о н хувьсгал, Цагаан хувьсгал үндэсний хөтөлбөрийн шугамаар өрхийн аж ахуйг хөгжүүлэх;

и/ажлын байр олноор бий болгож, бие биедээ байнга тусалж байгаа иргэд, айл өрхийг алдаршуулах, урамшуулах.

**Тав.Хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа, хүрэх үр дүн, санхүүжилт**

27.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа:

а / ө р х и й н амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөр нь 2000-2005 онуудыг хамарч 6 жилийн хугацаагаар 2 үе шаттайгаар үргэлжлэн явагдана;

б/эхний үе шат нь 2000-2002 онд 3 жил үргэлжлэх ба дунд хугацааны үнэлгээгээр хөтөлбөрт тодотгол хийж нэмэлт өөрчлөлт оруулж болно. Хоёрдахь үе шат нь 2003-2005 онд үргэлжлэн явагдаж хөтөлбөрийн үр дүнг тооцно.

28.Хүрэх үр дүн:

а/төрийн захиргааны төв, орон нутгийн бүх шатны байгууллага, өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, айл өрх, иргэд, төрийн бус байгууллагуудын оролцоо, хамтын хүчин чармайлт, нэгдмэл үйл ажиллагаа, гадаад орон, олон улсын байгууллагуудын дэмжлэг тусалцааны үр дүнд хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр амьжиргааны доод түвшингээс бага орлоготой өрхийн тоо 1999 онтой харьцуулахад 2003 оны эцэст 20, 2005 оны эцэст 40 хувиар тус тус буурсан байх;

б/амьдралын чадавхи сул

ерхийн амьдралын байдалд эерэг өөрчлөлт гарч, амьдралын чадавхи дунд ангилалд шилжих өрхийн тоо нэмэгдсэн байх;

в/өрхийн амьдрал дахь эрх зүйн зохицуулалт ихэсч, татвар төлөгчид, нийгмийн даатгалд хамрагдагсдын хүрээ өргөжихийн хэрээр амьжиргаа нь дээшилсэн иргэдээс улс орны хөгжилд оруулах хувь нэмэр нэмэгдэх;

г/ажиллах хүчний нөөц өсч, ажлын байр нэмэгдсэнээр жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний хүрээнд ажлын байр эрсдэлээс хамгаалагдсан байх;

д/нийт өрхийн 80-аас доошгүй хувь нь амьжиргааны нэн тэргүүний хэрэгцээгээ хангахад шаардагдах орлогын эх үүсвэртэй болсон байх;

е/орон нутагт мэдээлэл, сургалт, судалгаа, сурталчилгааны төв, мэдээллийн сүлжээ бий болсноор тодорхой мэргэжилгүй, боловсрол багатай, хөдөлмөрийн насны 300,0 мянган иргэдийг төрөл бүрийн сургалтад хамруулах.

## 29. Санхүүжилт:

Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөрийн санхүүжилтийг Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад бий болсон зээлийн эргэлтийн санг үргэлжлүүлэн ашиглах, улс, орон нутгийн төсвөөс хөрөнгө гаргах, гадаадын хандивлагч орнууд, олон улсын байгууллагуудын урт хугацааны хөнгөлөлттэй зээл, тусламжийг нэмэгдүүлэх, төрийн бус байгууллага, өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, буяны байгууллага, иргэдийн оролцоог эрчимжүүлэх, дотоод нөөц бололцоогоо илрүүлэн дайчлах замаар бүрдүүлнэ.

30. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр:

а/орон нутагт бий болсон зээлийн эргэлтийн сан;

б/улс, орон нутгийн төсвөөс олгох хөрөнгө;

в/хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл тусламж;

г/төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санаачилгаар бүрдүүлэх зээл, тусламж, хандивын хөрөнгө;

д/хөрөнгийн бусад эх үүсвэр.

## Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт, мониторинг

31. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд шийдвэрлэх зорилт:

Хөтөлбөрийг улс орны хөгжлийн бодлоготой уялдуулан, төрийн захиргааны төв, орон нутгийн болон төрийн бус байгууллага, гадаадын хандивлагчид, зээд, хоршооллогчид, өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, төрөл бүрийн ажил мэргэжлийн хүмүүс, иргэдийн дэмжлэг, оролцоотойгоор хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулна.

32. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын бүтэц:

а/хөтөлбөрийн удирдах дээд байгууллага нь Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих Үндэсний хороо /цаашид "Үндэсний хороо" гэх/ байна. Үндэсний хороог Ерөнхий сайд удирдана;

б/Үндэсний хороо нь орон тооны бус байгууллага бөгөөд Засгийн газар, яамд, төрийн бус байгууллага болон нийгмийн чиглэлийн үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэгч байгууллагууд, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын төлөөлөгчдөөс бүрдэнэ;



**в/Үндэсний хороо**  
нь хөтөлбөрийн хэрэгжилтийг улс орны нийгэм, эдийн засгийн бодлого, хүний хөгжлийн асуудлаархи бусад хөтөлбөрүүдтэй холбон авч үзэж цогцолбор үйл ажиллагаа явуулна;

**г/орон нутгийн түвшинд хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцсан орон тооны бус Зөвлөлийг холбогдох байгууллагуудын төлөөлөлтэйгээр Засаг даргаар ахлуулан байгуулж ажиллуулна;**

**д / ө р х и й н амьжиргааны чадавхийг дэмжих Үндэсний хорооны өдөр тутмын үйл ажиллагааг Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих хөтөлбөрийн газар /цаашид "хөтөлбөрийн газар" гэх/ гардан зохион байгуулж, мэргэжлийн удирдлага, дотоодын хяналтаар төв, орон нутгийн байгууллагуудыг хангана;**

**е / Ү н д э с н и й хороо, орон нутгийн зөвлөл, хөтөлбөрийн газрын дүрэм, үйл ажиллагааны чиглэл, хөтөлбөрийн газрын ажлын байрны тодорхойлолтыг Үндэсний хорооны хурлаар тус тус хэлэлцэж батална;**

**ж/яамд нь хөтөлбөрийн хүрээнд эрхэлсэн асуудлын чиглэлээр бодлого боловсруулан Үндэсний хороотой зөвшилцөн үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж хэрэгжүүлнэ;**

**з / х ө т ө л б ө р т тусгагдсан бодлогын шинжтэй арга хэмжээнүүдийг зохион байгуулах, хөрөнгө санхүүжилт олгохтой холбогдсон дүрэм, журам, бусад шаардлагатай баримт бичгийн төслийг хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцож байгаа тухайн хүрээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх ба тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах үүргийг Үндэсний хорооны удирдлагын дор Хөтөлбөрийн газар, төслийн нэгжүүд хариуцан**

**гүйцэтгэнэ;**

**и / Ү н д э с н и й хорооны дэргэд Судалгааны төв-Зөвлөлдөх хэсэг ажиллаж болно. Судалгааны төвийн бүрэлдэхүүнийг Засгийн газрын болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөгчид, эрдэм шинжилгээний ажилтнууд, төслийн мэргэжилтнүүдийг оролцуулан Үндэсний хороо батална;**

**к/судалгааны төв нь эдийн засаг, нийгмийн асуудлуудын харилцан хамаарлыг төр, засгийн бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үйл ажиллагаатай уялдуулан судалж, тэдгээрийн өөр хоорондын эерэг болон сөрөг нөлөөллийг цогцолбороор авч үзэж мэдээллээр хангах чиглэлээр ажиллана;**

**л/Засгийн газар болон хандивлагчид нь хөтөлбөрийн газрын үйл ажиллагааны зардлыг хариуцна;**

**м/аймаг, нийслэл, дүүрэгт хөтөлбөрийн хэрэгжилтийн асуудлыг хариуцсан орон тооны ажилтан байна. Сумдад ийм бүтцийг Засаг даргын Тамгын газрын эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудлаархи ажлын байрны нягтралыг сайжруулах замаар бий болгож ажиллуулна. Цаашид сумдад бие даасан бүтэц бий болгоход анхаарна.**

**33.Хөтөлбөрт хяналт, мониторинг хийх тогтолцоо:**

**а/хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт, мониторинг хийх үүргийг сум, дүүрэг, аймаг, нийслэлийн зөвлөлүүд, төрийн захиргааны төв байгууллагуудын дэргэдэх Мэдээлэл, үнэлгээ, хяналт, шинжилгээний албад хариуцна;**

**б/хөтөлбөрийн хяналт, мониторингийн үйл ажиллагаанд дэвшилтэт аргуудыг хэрэглэж, олон нийт, төрийн бус байгууллагуудыг өргөнөөр оролцуулна;**



в/хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт хийх нөхцөлийг бүрдүүлнэ.

### Долоо.Хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлтүүд

34.Үндсэн шалгуур үзүүлэлт:

а/амьжиргааны чадавхи сул өрхийн амьдралын түвшинг бууруулахгүй аажмаар ахиулах чиглэл баримтлах /статистик үзүүлэлт /;

б/амьжиргааны доод түвшингээс бага орлоготой өрх, иргэдийн ахуй амьдрал дээшилсэн байх /чанарын үзүүлэлт/;

в/амьжиргааны түвшингээс доогуур орлоготой иргэд нийгмийн хамгааллын эрх зүйн харилцаанд орж амьдралаа баталгаажуулан, эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмрээ оруулж эхлэх /хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн түвшин, татвар, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын түвшин/.

35.Эрүүл мэндийн арга хэмжээг үнэлэх үзүүлэлтүүд:

а/эх, нялхсын эндэгдлийн бууралтын хувь;

б/материаллаг бааз, үйлчилгээний орчин нь сайжирсан эмнэлгийн тооны өсөлт;

в/дэмжлэг, туслалцаа авсан баг, өрхийн эмчийн тооны өсөлт;

г/эмийн хангамж, эмийн үйлчилгээний хүртээмж, чанарын өсөлт.

36.Боловсролын талаар хэрэгжүүлэх арга хэмжээг үнэлэх үзүүлэлтүүд:

а/сургуулийн өмнөх боловсролын тогтолцоонд шинээр

хамрагдсан хүүхдийн тоо, үүнд тахир дутуу хүүхдүүдийн эзлэх хувь;

б/сургууль завсардалтын бууралтын хувь;

в/материаллаг бааз, сургалтын хөтөлбөр нь сайжирсан сургуулийн тооны өсөлт.

37.Ажлын байр бий болгох чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээг үнэлэх үзүүлэлтүүд:

а/бүрдүүлсэн санхүүгийн эх үүсвэр, хөрөнгийн хэмжээ;

б/үйл ажиллагааг нь урамшуулан дэмжсэн жижиг, дунд үйлдвэрийн тооны өсөлт;

в/бий болгосон ажлын байрны тоо, үүнд эмэгтэйчүүд, тахир дутуу иргэд ажиллаж байгаа ажлын байрны тооны өсөлт.

38.Санхүүгийн жижиг зээлийн үйлчилгээ хөгжүүлж, хувиараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг үнэлэх үзүүлэлтүүд:

а/бүрдүүлсэн нийт зээлийн сангийн хэмжээ;

б / ш и н э э р байгуулагдсан санхүү, зээлийн үйл ажиллагаа явуулдаг нэгжийн тоо;

в/зээл олгож бизнесийн үйл ажиллагааг нь урамшуулан дэмжсэн иргэдийн тоо, үүнд эмэгтэйчүүд, өрх толгойлсон эхчүүд, тахир дутуу иргэдийн эзлэх хувь.

39.Малгүй болон цөөн малтай иргэдийг малжуулах арга хэмжээг үнэлэх үзүүлэлтүүд:

а/шинээр малтай болж мал маллагааны арга ухаанд суралцсан айл өрхийн тооны өсөлт;



б/малжуулсан цөөн малтай айл, өрхийн тоо, үүнд хамрагдсан эмэгтэй тэргүүлэгчтэй өрх ба тахир дутуу хүмүүсийн эзлэх хувь;

в/малын тоо, малжуулах арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ.

40. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээг үнэлэх үзүүлэлтүүд:

а/шинээр гаргасан ба сэргээн засварласан худаг, булаг, шандын тоо;

б/нөхөн сэргээсэн ой модны талбайн хэмжээ /метр кв/;

в/шинээр цэцэрлэгжүүлсэн, тохижуулсан талбайн хэмжээ /метр кв/.

41. Судалгаа, мэдээллийн сүлжээг боловсруулж болгох арга хэмжээг үнэлэх үзүүлэлтүүд:

а/удирдлагын мэдээлэл, судалгааны төвөөс хөтөлбөрт оролцогчдыг шаардлагатай судалгаа, мэдээлэл, арга зүйгээр хангасан байх /үйл ажиллагааны үр дүн, мэдээллийн чанар/;

б/орон нутагт хөдөлмөр, нийгмийн хамгааллын мэдээллийн сүлжээ бий болж, ядуурлыг бууруулах үйл ажиллагааны болон зээлийн эргэлтийн сангийн талаархи мэдээллийн сан байгуулах.

42. Мэргэжил, ур чадварын болон амьдрах арга ухааны сургалт явуулах арга хэмжээг үнэлэх үзүүлэлтүүд:

а / ш и н э э р байгуулагдсан сургалт, мэдээлэл, судалгаа, сурталчилгааны төвийн тоо;

б/мэргэжил, ур чадвар, амьдрах арга ухааны сургалтад хамрагдсан иргэдийн тоо, үүнд эмэгтэйчүүд, өрх толгойлсон эхчүүд, тахир дутуу иргэдийн эзлэх хувь.

43. Улсын болон хувийн салбарын оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг үнэлэх үзүүлэлтүүд:

а / и р г э д и й н амьжиргааны чадавхийг дэмжихэд хувь нэмрээ оруулсан аж ахуйн нэгжийн тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ;

б/хөтөлбөрийн үйл ажиллагаанд хамрагдсан төрийн бус байгууллагуудын тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ;

в/үйл ажиллагаа явуулсан шашны болон буяны байгууллагуудын тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ;

г/хөтөлбөрт хамрагдан түүний үр шимийг хүртсэн нийт өрх, иргэдийн тоо, түүний дотор эмэгтэйчүүд, өрх толгойлсон эхчүүд, тахир дутуу иргэдийн эзлэх хувь.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 6 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 94

Улаанбаатар хот

**Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Сум, хороонд ажиллаж байгаа

цагдаагийн алба хаагчийн эхнэр (нөхөр)-ийг ажлын шаардлагаар цагдаагийн туслах ажилтнаар хуульд нийцүүлэн томилон ажиллуулбал уг алба хаагчийн сарын үндсэн





цалингийн 50 хүртэл хувьтай тэнцэх хэмжээгээр сар тутам цалинжуулж байхаар тогтоосуугай.

2.Сумдад нэг, аймгийн төвд таваас доошгүй орон сууцны тус тус төрийн өмчлөлд байлгаж Цагдаагийн ерөнхий газрын томилолтоор орон нутагт ажиллах алба хаагчдыг орон сууцаар хангаж байх арга хэмжээ авахыг аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

3.Цагдаагийн алба хаагчдын цалин урамшууллыг нэмэгдүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажиллах нөхцөл бололцоог сайжруулах, уналга, холбоо, техник хэрэгслээр хангах арга хэмжээг жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг

дарга нарт даалгасугай.

4.Цагдаагийн байгууллагад нэг тэргүүнд шаардлагатай байгаа хавсралтад дурдсан зарим автомашин, техник хэрэгсэл худалдан авахад зориулж 395 /гурван зуун ерэн таван/ сая төгрөгийг төсвийн зээлийн хэлбэрээр 2000 оны Пулиралд багтаан олгож, 2001 оны төсөвт тусган тооцож барагдуулахыг Сангийн сайд Я.Очирсүхэд зөвшөөрсүгэй.

**Монгол Улсын Ерөнхий сайд**

**Р.АМАРЖАРГАЛ**

**Хууль зүйн сайд**

**Д.ГАНБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 6 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 95

Улаанбаатар хот

### Хөтөлийн цемент, шохойн үйлдвэрийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Бүтээгдэхүүний зах зээлийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан Хөтөлийн цемент, шохойн үйлдвэрийн хүчин чадлын ашиглалт хангалтгүй, үр ашиг буурч борлуулалт эрс багасч, өр төлбөр үлэмж өсч санхүүгийн хүнд байдалд орсны гадна менежментийн чадвар доройтож үйлдвэр болон тосгоны нийгмийн асуудлыг бүрэн шийдвэрлэх чадваргүй болсонтой холбогдуулан Төрийн өмчийн хороо, Монгол-Оросын хамтарсан "Эрдэнэт" үйлдвэрийн санал, Хөтөлийн цемент, шохойн үйлдвэрийн хамт олны төлөөлөгчдийн хүсэлтийг харгалзан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

тооцон зохицуулахыг Сангийн сайд Я.Очирсүх, Төрийн өмчийн хорооны дарга Д.Зоригт нарт зөвшөөрсүгэй.

2.Хөтөлийн цемент, шохойн үйлдвэрийн цаашдын төлөв, зах зээл, үйл ажиллагаа нь хамтарсан "Эрдэнэт" үйлдвэрээс хамааралтай байдлыг харгалзан уг үйлдвэрийн менежментийн асуудлыг хамтарсан "Эрдэнэт" үйлдвэрт хариуцуулж, үйлдвэрийн ерөнхий захирлыг гэрээний үндсэн дээр томилон ажиллуулахыг Дэд бүтцийн хөгжлийн сайд Г.Батхүү, Төрийн өмчийн хорооны дарга Д.Зоригт, "Эрдэнэт" үйлдвэрийн ерөнхий захирал Д.Дорлигжав нарт даалгасугай.

1.Сүүлийн жилүүдэд хамтарсан "Эрдэнэт" үйлдвэрээс Хөтөлийн цемент, шохойн үйлдвэрт нийлүүлсэн бараа, материал, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний төлбөрийн хуримтлагдсан үлдэгдэл болох 4,1 (дөрвөн тэрбум нэг зуун сая) тэрбум төгрөгийн өрийг улсын төвлөрсөн төсөвт хамтарсан "Эрдэнэт" үйлдвэрийн 2000 оны үйл ажиллагааны ашгаас оруулахаар төлөвлөсөн 26,56 (хорин зургаан тэрбум таван зуун жаран сая) тэрбум төгрөгөөс хасч

**Монгол Улсын Ерөнхий сайд**

**Р.АМАРЖАРГАЛ**

**Сангийн сайд**

**Я.ОЧИРСҮХ**

**Дэд бүтцийн хөгжлийн сайд**

**Г.БАТХҮҮ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гарган, Хаяг: "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 329612  
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хөвлөх хэсэгт хэвлэв.

☎ 329487